

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЗҮЙЛ ХЭРЭГЛЭСЭН ҮЕДЭЭ
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДСОН ЖОЛООЧИД ХҮЛЭЭЛГЭХ
ХАРИУЦЛАГА БА ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ
RESPONSIBILITY AND ITS CONSEQUENCES FOR DRIVERS WHILE
DRIVING VEHICLES WHILE USING ALCOHOL BEVERAGES**

*Б.Тэлмэн
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч
B.Telmen- Graduate student,
University of law Enforcement
police chief lieutenant*

Хураангуй. Зам тээврийн осол, хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирох зонхилох шалтгааны нэг нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох үйлдэл ордог.

Энэхүү өгүүлэлд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохтой холбоотой Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, нэмэлт өөрчлөлт орсноос хойших зам тээврийн хэрэг, осол, зөрчлийн талаарх нөхцөл байдалд дүн шинжилгээ хийнэ.

Abstract: Driving under the influence of alcohol is one of the leading causes of loss of life and health in traffic accidents and incidents.

This article will analyze the situation regarding road traffic cases, accidents and violations after the amendments and amendments to the Law on Criminal and Violations related to driving under the influence of alcohol.

Түлхүүр. Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, жолооч, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, зам тээврийн осол, хэрэг, зөрчил

Keyword: Criminal law, Misdemeanor law, drunk driving, traffic accidents, cases, violations

Оршил. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаагаар өдөр бүр 3500 гаруй хүн, жил бүр 1.3 сая хүн зам тээврийн ослоор нас барж, 50 сая хүн гэмтэж, 1 жилд 186300 хүүхэд, 1 өдөрт 500 гаруй хүүхэд зам тээврийн ослын улмаас амь насаа алддаг¹ гэсэн харамсалтай тоон мэдээлэлтэй байна.

Зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг тогтоох, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийн оролцоог зөвхөн тооцох нь хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль шүүхийн байгууллагын үйл ажиллагааг зөв шударга явуулах гарцаагүй нөхцөлийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл “Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам-Орчин” гэсэн системийн хоорондын харилцан хамаарал, түүний бүрдүүлэгч элемент нэг бүрийг зөв тооцох зайлшгүй шаардлагатай болохыг нэгэнт тодорхойлжээ².

Тэгвэл Тээврийн цагдаагийн албаны 2023 оны статистик тоон мэдээлэлд Улсын хэмжээнд 25255 зам тээврийн осол бүртгэгдсэнээс осолд нөлөөлөгч хүчин зүйлсийн нэг болох хүнээс шалтгаалсан 25149 буюу 99.6%-ийг эзэлсэн байна. Хүний хүчин зүйл дотроо жолоочоос шалтгаалсан 24574 зам тээврийн осол бүртгэгдсэний 1082 буюу 4.4% нь согтуу жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалж байна³.

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас 2021-2030 оныг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 10 жил болгон зарлаж, зам тээврийн ослыг 50%-иар бууруулахаар төлөвлөн

¹ <https://worlddayofremembrance.org>. //Татаж үзсэн: 29.02.2024 World day of remembrance for road traffic victims

² Мөнхбаяр Р., Энхболд Э., Зам тээврийн ослыг шалгах ажиллагаа, ослын шалтгаан, нөхцөлийг тогтоох зарим арга зам, хууль тогтоомжийн эмхэтгэл –Уб., 2019. 6 дахь тал

³ Тээврийн цагдаагийн алба Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл Уб., 2022. 35 дахь тал

ажиллаж байна. Тус ажлыг зохион байгуулахын тулд тодорхой хэдэн зорилт тавьсны нэг нь хууль эрх зүйн орчныг сайжруулах юм⁴.

Үндсэн хэсэг.

1.1 Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох хэрэг, зөрчлийн талаарх ойлголт.

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаг согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт "согтууруулах ундаа" гэж хүнсний зориулалтын түүхий эдээр үйлдвэрлэсэн спирт, 2 хувиас дээш хатуулагтай нэршлээс үл хамаарсан бүх төрлийн архи, дарс, шар айраг зэргийг" гэж заасан байдаг.

Тэгвэл жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журмын 2.5 дугаар зүйлд "Шалгаж, тогтоох ажиллагааны үр дүнд шалгуулагчийн амьсгал дахь спиртийн агууламж 0,20 промилль (‰), эсхүл цусан дахь спиртийн агууламж 0,5 промилль (‰) илэрвэл согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн гэж үзнэ"⁵ гэж заажээ.

Согтууруулах ундаа нь хүний биед ууснаас 2 минутын дараа ходоодоор шимэгдэж цусанд орно. Хамгийн түрүүнд их тархины гадрын эд эс нэрвэгдэх тул болзолт хариу урвалын үйл ажиллагаа муудна. Их тархины гадрын духны хэсгийн эсэд архи нөлөөлвөл сэтгэл хөдлөл өөрчлөгдөж хий баярлах, дэмий инээх, эргэцүүлэн бодох чадварыг өнгөцхөн болгодог.

Нөлөөллийн зэрэг

0.5 – 1.5‰ – Эхний зэрэг хялбар байдаг. Энэ нь архины дараа хэдэн минут болдог. Булчин суларч, ядрах нь муудаж, сэтгэлийн хөдөлгөөн нэмэгдэж, үйл ажиллагаа нэмэгдэнэ.

1.5 – 2.5‰ – Хоёр дахь зэрэг дунд. Илтгэл нь илэрхий илэрхий биш бөгөөд зохицуулалт буурч байна. Энэ нь согтууруулах ундааны дунд зэрэг янз бүрийн адал явдлууд, тэмцэлд хүн ордог бөгөөд түрэмгийлэл нэмэгддэг.

2.5 – 3 ‰ – Гурав дахь зэрэг нь хүнд. Хөдөлгөөнийг зохицуулах, зохицуулах. Ухаан алдах магадлал. Энэ үе шатанд ихэвчлэн amnesia дагалддаг.

3-4‰ – Дөрөв дэх зэрэг нь маш хэцүү байдаг. Хүн хөдөлж ярих чадваргүй. Энэ үе шатанд тухайн хүн бусад хүмүүсийг танихгүй бөгөөд юу болж байгааг ойлгохгүй байна.

5-6‰ – Тав дахь шат нь этилийн спиртийн агууламж хэт их юм. Мэдрэлийн систем, зүрх, элэгний гэмтэл. Бие нь хүчтэй хордлогыг даван туулж чадахгүй.

Промель гэх хэмжүүр нь 1000 миллилитр амьсгал, цусанд агуулагдах спиртийг хэмжидэг. Жишээ нь: 1‰ нь 1/1000 г/мл (1000 миллилитр амьсгал, цусанд 1 грамм спирт) агуулагдана.⁶

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулсан этгээд дахин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2023 оны 12 дугаар сарын 7-ны өдөр УИХ-аар эцэслэн баталсан. Уг нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тухайлбал:

1. Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна" гэж байсныг хасаж Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж, хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний

⁴ <https://cdn.who.int>. //Татаж үзсэн: 01.03.2024 Decade of action for road safety 2021-2030

⁵ <https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=34&useg=%D0%B6&active=1&sort=title&page=1>

⁶ <https://oat.mn/post-24121/>


төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”⁷ гэж шинээр тусгасан;

2. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсгүүдэд заасан шийтгэл оногдуулах харицлагыг нэмэгдүүлсэн;

3. Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн зүйлийн 3.1, 3.2 дахь заалтуудыг нэгтгэж, “5.1.согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, 5.2.тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, 5.3.согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна”⁸ гэж тус тус тусгасан байна.

1.2. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон хэрэг, зөрчлийн нөхцөл байдал.

Зураг 1. Сүүлийн 6 жилийн хугацаанд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил илрүүлэлтийн тоон судалгаа⁹.



Дээрх графикаас харахад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн илрүүлэлт 2020 оноос бусад жилүүдэд өсөлттэй байна. Учир нь 2020 онд цар тахлын хөл хорионоос шалтгаалсан иргэдийн зорчих хөдөлгөөн буурсан. Үүнтэй шууд холбоотой юм.


Зураг 2. Сүүлийн 6 жилийн хугацаанд зам тээврийн ослын улмаас нас барсан хүн, согтуу жолоочийн буруутай үйлдлийн улмаас нас барсан хүний тоон судалгаа¹⁰.

⁷ Төрийн мэдээлэл. 2002. №05. //Монгол Улсын эрүүгийн хууль

⁸ Төрийн мэдээлэл. 2017. №24. //Монгол Улсын Зөрчлийн тухай хууль


⁹ Тээврийн цагдаагийн алба Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл Уб., 2018-2023

¹⁰ Тээврийн цагдаагийн алба Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл Уб., 2018-2023




Дээрх графикаас харахад 2020, 2021 онуудад зам тээврийн ослын улмаас нас барсан хүмүүсийн тоон үзүүлэлт бусад жилүүдээс бууралттай байна. Энэ нь мөн цар тахлын хөл хорионоос шалтгаалсан иргэдийн зорчих хөдөлгөөн буурсантай холбоотой. Тэгвэл согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан нас баралтын тоон үзүүлэлт мөн жил бүр буурсныг зураг 1, 2-оос харахад Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулдаг нэгдсэн болон хэсэгчилсэн хяналт шалгалтаар согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил илрүүлэлтэй шууд холбон ойлгож болох юм.

Зураг 3. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодоход хүлүүлэлгэх хариуцлагыг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан хийсэн харьцуулсан судалгаа.



Дээрх графикаас харахад нэмэлт өөрчлөлттэй холбоотой Тээврийн цагдаагийн албаны энэ оны эхний 02 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд бүртгэгдсэн согтуугаар үйлдэгдсэн хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол, согтуу жолоочийн улмаас нас барсан хүн, гэмтсэн хүн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож, эрүүлжүүлэгдсэн хүний тоон мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулалт хийхэд согтуугаар үйлдэгдсэн осол 11 нэгжээр өссөн боловч бусад ноцтой хүний амь нас хохирсон зам тээврийн осол 2 нэгжээр буурсан, гэмтсэн хүн 8 нэгжээр буурсан, эрүүлжүүлэгдсэн хүний тоо 3 дахин буурсан эерэг үзүүлэлтэй байна.

Зураг 3. Эхний 09 сарын харьцуулсан судалгаа.



Дүгнэлт. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохтой холбоотой хүлээлгэх хуулийн хариуцлагыг нэмэгдүүлснээр эхний 1 сарын хугацаанд тодорхой хэмжээний эерэг үзүүлэлтүүд харагдлаа. Дан ганц цагдаагийн байгууллагын хяналт шалгалтаар дээрх согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас учрах зам тээврийн ослын хор уршгийг бууруулах нь хангалтгүй юм. Хууль, эрхзүйн орчныг бүрдүүлж, цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

Санал. Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн жолооч нарын амьсгал болон цусан дахь спиртийн агууламжаас хамаарч хариуцлага тооцох системийг ялгамжтай болгох Жишээ нь:

Австрали улсад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд тавих хяналт нь:

a. 0.20-0.50 промилл 1100 доллар, 6 сараар эрх хасах

b. 0.50-0.80 промилл анх удаагийн тохиолдолд 1100 доллар, 6 сараар эрх хасах, давтан үйлдсэн тохиолдолд 2200 хүртэл доллар, 1 жилээс дээш хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасна.

c. 0.80-1.50 промилл анх удаагийн тохиолдолд 2200 хүртэл доллар, 1 жилээс дээш хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасна, давтан үйлдсэн тохиолдолд 3300 хүртэл доллароор торгож, 2 жилээс дээш хугацаагаар эрх хасахаас гадна 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

d. 1.5 промиллоос дээш байвал анх удаагийн тохиолдолд 3300 хүртэл доллароор торгож, 1 жилээс дээш хугацаагаар эрх хасахаас гадна 18 сар хүртэл хугацаагаар хорих бөгөөд давтан үйлдсэн тохиолдолд 5500 хүртэл доллароор торгож 3 жилээс дээш хугацаагаар эрх хасахаас гадна 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Австралид долоо хоногийн доод хөлс 570 австрали доллар. Энэ нь өдрийн 100 ам.доллар. ажлын 22 өдрөөр 22000 ам.доллар байна. Энэ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон хүнд хүлээлгэх хариуцлага нь үндсэн цалингийн хэмжээний 50%-250% хувьтай тэнцүү байна¹¹;

2. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон жолоочид Зөрчлийн тухай хуулиар 400 нэгжээр торгуулийн арга хэмжээ тооцож байгаа боловч мөн хуулийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтан, шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг 50 хувиар хөнгөрүүлнэ” гэж нэмэлт өөрчлөлт оруулсан нь нөгөө талаас хариуцлагыг

¹¹ <http://www.traffic-institute.mn/>

хөнгөрүүлж байгаа хэлбэр юм. Иймд нийгэмд учруулах хор хохирол ихтэй зөрчил үйлдсэн хүнд хамаатуулахгүй байх шаардлагатай;

3.Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ замын гарц, гарамгүй хэсгээр гарч зам тээврийн осол, хэрэгт өртсөн, бусдын хөдөлгөөнд саад хийсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын хууль тогтоомж:

-Монгол Улсын Эрүүгийн хууль

-Монгол Улсын Зөрчлийн тухай хууль

Ном, сурах бичиг, гарын авлага:

-Р.Мөнхбаяр, Э.Энхболд, Б.Далайцэрэн. Зам тээврийн ослыг шалгах ажиллагаа, ослын шалтгаан, нөхцөлийг тогтоох зарим арга зам, хууль тогтоомжийн эмхэтгэл. -УБ.,2019.

-Тээврийн цагдаагийн алба. Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. -УБ.,2022, 2023.

Цахим эх сурвалж:

-<https://worlddayofremembrance.org>.

-<https://cdn.who.int>.

--oOo--